



## НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/189

Улаанбаатар хот

### “Мод тарих үндэсний өдөр”-ийг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “л”, 29.1.6 “а”, 29.2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 63 дугаар зарлиг, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/323 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд Мод тарих “Үндэсний өдөр”-ийг 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг өргөнөөр оролцуулж, дүүргийн ногоон бүс, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, мод тарих ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бүх нийтийн мод тарих үндэсний өдрөөр Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад сургууль, цэцэрлэг, иргэн аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн эзэмшлийн газарт мод тарьж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Дүүргийн нутаг дэвсгэрт харьяалагдах иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд, албан хаагчдаа идэвхтэй хамруулж, өөрийн амьдарч буй орчиндоо мод тарьж ажиллахыг Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нар, хороодын засаг дарга нар болон Засаг даргын Тамгын газар /И.Баттөгс/-т тус тус үүрэг болгосугай.

4. Ажлын хэсгээс зохион байгуулж буй ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллахыг Хэвлэл мэдээллийн албанд даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг /Б.Батбаяр/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.БАЯРМӨНХ

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
2021 оны 02 дугаар сарын 02 -ны  
өдрийн 4129 дугаар захирамжийн  
1 дүгээр хавсралт



“МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ИЙГ ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Баянзүрх дүүргийн Дэд бүтэц, хот  
төлөвлөлтийн асуудал хариуцсан  
Засаг даргын орлогч  
Б.Батбаяр

Гишүүд:

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Төрийн захиргааны  
удирдлагын хэлтсийн дарга  
Б.Бат-эрдэнэ

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Хууль зүйн  
хэлтсийн дарга  
Б.Мөнгөншагай

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Хүнс, худалдаа,  
үйлчилгээний хэлтсийн дарга  
Л.Бадамханд

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Төлөвлөлт,  
гүйцэтгэлийн хяналт  
шинжилгээний хэлтсийн дарга  
З.Нямцогт

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Нийгмийн  
хөгжлийн хэлтсийн дарга  
Г.Шүрэнцэцэг

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Төрийн сангийн  
хэлтсийн дарга  
Б.Уянга

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Цэргийн штабын  
дарга, дэд хурандаа  
Т.Амартогтох

Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн  
газар Цагдаагийн дэд хурандаа  
П.Очбадрах

Баянзүрх дүүргийн мэргэжлийн  
хяналтын хэлтсийн дарга  
Д.Цэнд-очир

Баянзүрх дүүргийн Газар зохион  
байгуулалтын албаны дарга  
Д.Бат-Өлзий

Баянзүрх дүүргийн Боловсролын  
хэлтсийн дарга  
Б.Ганбат

Баянзүрх дүүргийн хөгжлийн  
төвийн дарга  
Г.Мөнхчимэг

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Аж ахуйн тасгийн  
дарга  
Д.Батцэнгэл

Баянзүрх дүүргийн Нийтлэг  
үйлчилгээний газар-1 ОНӨААТҮГ  
Д.Өлзийдэмбэрэл

Баянзүрх дүүргийн Нийтлэг  
үйлчилгээний газар-2 ОНӨААТҮГ  
Ц.Ууганбаяр

Баянзүрх дүүргийн Нийтлэг  
үйлчилгээний газар-3 ОНӨААТҮГ  
Т.Энхжин

Баянзүрх дүүргийн Нийтлэг  
үйлчилгээний газар-4 ОНӨААТҮГ  
П.Дэлгэрдалай

Баянзүрх дүүргийн Нийтлэг  
үйлчилгээний нэгдсэн авто бааз  
ОНӨААТҮГ

Г.Батболд

Баянзүрх дүүргийн Хөрөнгө  
оруулалт бүтээн байгуулалтын төв  
ОНӨААТҮГ

Б.Бямбажаргал

Баянзүрх дүүргийн Засаг дарга  
нар 28 хорооны


Баянзүрх дүүргийн Хэвлэл  
мэдээллийн алба

Баянзүрх дүүргийн Засаг даргын  
Тамгын газрын Тохижилт, нийтийн  
аж ахуйн хэлтсийн дарга

Б.Мөнх-эрдэнэ

Нарийн бичгийн дарга:

Баянзүрх дүүргийн Засаг даргын 2021 оны  
05 дугаар сарын 07-ны өдрийн 7/189 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт



## БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ АЖЛЫН УДИРДАМЖ

### Зорилго :

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигаар батлагдсан “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр дүүргийн нутаг дэвсгэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх, агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчноо хамгаалах үйлсэд хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

**Мод тарих газар:** Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, ерөнхий боловсролын сургууль, эмнэлэг, цэцэрлэг, дүүргийн гутаг дэвсгэрт ажиллаж амьдарч буй иргэн аж ахуйн нэгж байгууллага өөрийн эзэмшлийн талбайд болон зөвшөөрөл бүхий нийтийн эзэмшлийн зам талбайд.

**Мод тарих хугацаа:** 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдөр 10 цагт эхэлнэ.

**Зохион байгуулагч:** Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар

### Ажил үүргийн хуваарь :

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах хэлтэс, ажилтан
1	2	3	4
1.	Баянзүрх хайрхан ууланд, Д.Сүхбаатарын гэрийн буйр	2021.05.15	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчид
2.	Мод тарих харьяа хэлтэс албад, хороод өөрийн эзэмшлийн газарт ажлыг эхлэх, Иргэд оршин суугчид өөрийн амьдарч буй газарт мод тарьж ажиллах	2021.05.15	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс Дүүргийн 28 хороод

1	2	3	4
3.	Бүх нийтээр мод тарих ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулах	2021.05.15	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс Төрийн ба төрийн бус байгууллагууд Дүүргийн 28 хороод
4.	Хороод нутаг дэвсгэрийн хэмжээнд таригдсан модны урьдчилсан дүн мэдээг Дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст хүргүүлэх /14 цагт багтаан/	2021.05.15	Дүүргийн 28 хороод
5.	Хэлтэс албад, сургууль, цэцэрлэгүүд, иргэн аж ахуйн нэгжүүд тарьсан модны тоо хэмжээ тайлан хэлбэрээр харьяа нутаг дэвсгэрийн хороодод хүргүүлэх.	2021.05.09-10	Дүүргийн харьяа хэлтэс албад, Дүүргийн 28 хороод
6.	Хороод дүн мэдээг эцсийн байдлаар нэгтгэн хүснэгт болон тайлан хэлбэрээр Дүүргийн Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст хүргүүлэх <a href="mailto:tohijilt.bzd@gmail.com">tohijilt.bzd@gmail.com</a>	2021.05.17	Дүүргийн 28 хороод
7.	Хороодоос ирүүлсэн дүн мэдээг нэгтгэн Нийслэлийн Байгаль орчны газарт хүргүүлэх.	2021.05.17	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс Төрийн ба төрийн бус байгууллагууд Дүүргийн 28 хороод

#### Мэдээг нэгтгэх:

1. Ажлын хэсгийн гишүүд бүр өөрсдийн хариуцсан чиглэлийн дагуу, Засаг даргын харьяа хэлтэс, албад, аж ахуйн нэгж байгууллага, Их дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, иргэдийг татан оролцуулж ажилласан тухай мэдээг нэгтгэн, [tohijilt.bzd@gmail.com](mailto:tohijilt.bzd@gmail.com) хаягаар /Оролцсон иргэн, аж ахуйн нэгж, таригдсан мод, бут, сөөгний тоо хэмжээ нэр төрлөөр ангилан фото зургаар баталгаажуулан задгай тайлан, хавсралт хүснэгтийн дагуу тоо хэмжээг ирүүлэх/ Урьдчилсан дүн мэдээг 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 14 цагаас өмнө, Эцсийн дүн мэдээг 2021 оны 05 дугаар сарын 17-ний өдрийн 16 цагаас өмнө ирүүлэх;

2. Мод тарих ажлыг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон өөрийн цахим хуудсаар сурталчлах;
3. Хэрэглэгдэх багаж хэрэгсэл хомс тул, мод тарих ажилд оролцож буй хүн бүр бээлий, хүрз, хувинтай ирэх;
4. Батлагдсан хуваарийн дагуу нэр заагдсан ажилтан албан хаагчид бэлтгэл ажлыг ханган зохион байгуулж ажиллах;

**Ажлын дүнг гаргах:** Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Байгаль орчны газар, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албанд дүүргийн хэмжээнд бүх нийтээр тарьсан мод, бут, сөөгийн дүнг нэгтгэж гарган хүргүүлнэ. Мөн дүүргийн нутаг дэвсгэрт бүх нийтээр мод тарих өдөр зохион байгуулсан ажлын үр дүн, мэдээг илтгэх хуудсаар Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нарт тус тус танилцуулна.